


ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/30-2023/02/03

ТОП 20 индекс



ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Атар-Өргөө	3,992,170,000
Голомт Банк	1,709,788,299
АПУ	382,828,100
Эрдэнэ ресурс девелопмент	170,741,018
Монголын хөрөнгийн бирж	167,798,657

ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
ЖиДакс	3,072,000	18.58%
Стандарт Проперти	1,587	15.00%
Сонсголон Бармат	8,855	15.00%
Монгол Дизель	10,120	14.84%
Могойн Гол	800,400	13.60%

ХАМГИЙН ИХ БУУРАЛТТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Хөх Ган	233,027	-12.82%
Баянгол Зочид Буудал	210,700	-12.75%
Фронттиер Лэнд Групп	142,200	-10.00%
Булигаар	294,334	-8.69%
Авто Импекс	50,400	-7.94%

МХБ-ын Топ 20 индекс өнгөрсөн долоон хоногт 38,047 нэгжид хүрч өнгөрсөн 7 хоногоос 0.46 %-иар нэмэгдэж харьцангуй тогтвортой үзүүлэлттэй байв. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.91 их наяд ₮ хүрээд байна.

Энэ оны эхний 7 хоногт Монголын хөрөнгийн биржээр 86 компанийн 15.9 тэрбум ₮-ийн 6.5 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан байна.

Үүнээс 160.2 сая ₮-ийн ХБҮЦ, 164 сая ₮-ийн компанийн бонд, 39.8 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 15.5 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан эдгээр хувьцаанууд нь өнгөрсөн 7 хоногийн нийт хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны 41.4%-ийг эзэлж байгаа бол Атар өргөө ХК арилжааны үнийн дүнгээр тэргүүлж дангаараа өнгөрсөн 7 хоногийн нийт хувьцааны арилжааны 25.9%-ийг бүрдүүлсэн байна. Харин хөрвөх чадвар өндөртэй Голомт банк, Монголын хөрөнгийн бирж, АПУ ХК мөн арилжааны үнийн дүнгээр тэргүүллээ.

Өнгөрсөн 7 хоногт ЖиДакс ХК 3.1 сая ₮-ийн арилжаагаар 18.58%-ийн өсөлт үзүүлж өсөлтийн хувь хэмжээгээрээ тэргүүлсэн байна. Хэдийгээр өндөр өсөлт үзүүлсэн боловч арилжааны үнийн дүн харьцангуй бага байна. Бусад үнэт цаасны хувьд ч мөн үнийн дүн харьцангуй бага байна.

Металл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хөх Ган ХК нь өнгөрсөн долоон хоногт 233,027 ₮-ийн арилжаагаар 12.82%-ийн уналт үзүүлсэн байна. Уналтын хувь хэмжээгээр тэргүүлсэн үнэт цаасны арилжааны үнийн дүн мөн харьцангуй бага байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn


www.rhinosinvest.mn

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/01/30-2023/02/03


ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Сэндли Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа 2023/01/30-ны өдөр эхэллээ



Сэндли Бондын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансанд эзэмшиж буй бондыг байршуулж дууссан тул хоёрдогч зах зээлийн арилжаа 2023/01/30-ний өдрөөс Монголын хөрөнгийн бирж дээр эхлээд байна.

Монгол улсын эдийн засаг 2022 онд 4.5%-иар өссөн байна.



2022 онд манай улсын эдийн засаг 4.5 хувиар өссөн гэж Үндэсний статистикийн хороо тооцоолсон байна. Европын эрчим хүчний салбар тогтворжиж, БНХАУ хилээ нээсэн нь Олон Улсын Валютын Сан эдийн засгийн төсөөллийг шинэчлэхэд нөлөөлсөн ч Монгол Улсын эдийн засагт тодорхой хэмжээнд нөлөөлнө гэж үзэж буйгаа Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар мэдээллээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

